



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Журам, загвар батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.10 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийлгэх, аудитын тайланг баталгаажуулах түр журам" -ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журамд заасны дагуу аудитын ажлыг зохион байгуулж, чанарын хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор /Ц.Наранчимэг/-т даалгасугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгүүлэх журам", мөн 2009 оны 108 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, Нийслэлийн аудитын газраас гэрээгээр аудит хийлгэх журам"-ыг тус тус хүчингүй болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2017 оны 02 дугаар сарын 23-ны
өдрийн 2/29 дугаар тушаалын
хавсралт

УХА0122

САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ГЭРЭЭГЭЭР АУДИТ ХИЙЛГЭХ, АУДИТЫН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын Ерөнхий аудитор Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5¹-д заасны дагуу Төсвийн захирагчдийн санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын хуулийн этгээд /цаашид "гүйцэтгэгч" гэх/-ээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, чанарын хяналт тавихад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2² дахь хэсэг, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5³ дахь заалтыг хэрэгжүүлэхийн тулд Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2⁴, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10⁵ дахь заалтын дагуу Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд /цаашид "төрийн өмчит хуулийн этгээд" гэх/-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн сонгосон аудитын хуулийн этгээд /цаашид "гүйцэтгэгч" гэх/-ийн гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад гэрээгээр чанарын хяналт тавих, баталгаажуулахад энэхүү журмыг баримтлана.

1.3. Энэхүү журам нь "Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ"-ний загвар нэгдүгээр хавсралт, "Аудитын чанарын хяналтын гэрээ"-ний загвар хоёрдугаар хавсралт, "Гэрээт ажилтан ажиллуулах тухай гэрээ" -ний загвар гуравдугаар хавсралтаас тус тус бүрдэнэ.

¹ 18.5.Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Ийнхүү гүйцэтгэсэн аудитын тайлангийн чанарыг төрийн аудитын байгууллага баталгаажуулна. Гэрээгээр аудит хийлгэх, аудитын тайланг баталгаажуулах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

² 54.2.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна.

³ 8.9.5.төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

⁴ 4.2.Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой компанид аудит хийхдээ Компанийн тухай хуулийн 76.1.10-т заасныг мөрдөнө.

⁵ 76.1.10.аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;

Хоёр. Санхүүгийн тайланд гэрээний үндсэн дээр аудит хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

2.1. Үндэсний аудитын газар /цаашид “захиалагч” гэх/-ыг төлөөлж Санхүүгийн аудитын газар /САГ/ дараах үүрэг гүйцэтгэнэ:

2.1.1. САГ аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий гүйцэтгэгчийн жагсаалтыг жил бүр шинэчлэн гаргах;

2.1.2. Тухайн жилд санхүүгийн тайланд аудит хийх шаардлагатай нийт төсвийн захирагчид, төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг шинэчлэн гаргах;

2.1.3 2.1.2-т заасан жагсаалтаас САГ, Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүний нөөц, боломжит цаглабарт хугацааг харгалзан тухайн шатны төсвийн захирагч, УИХ-аас аудит хийлгэхээр захиалсан төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг гаргах;

2.1.4 Өмнөх жилийн гэрээний биелэлтийн дүнг гаргаж, цаашид гэрээг үргэлжлүүлэх эсэх талаарх саналаа Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулах;

2.1.5 Гүйцэтгэгчээр гэрээний үндсэн дээр аудит хийлгэх төсвийн захирагчийн санхүүгийн тайлангийн нэрс, түүнийг бүлэглэн багц үүсгэсэн жагсаалтыг ҮАГ-ын Удирдлагын зөвлөл /цаашид УЗ гэх/-ийн хуралд танилцуулж, Монгол Улсын Ерөнхий аудиторoor батлуулах;

2.2. Стратеги удирдлагын газар /цаашид “СУГ” гэх/ гүйцэтгэгчийн чадавхийн шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагыг холбогдох хууль, журам, зааварт орсон өөрчлөлтийг тусган боловсруулж, ҮАГ-ын УЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн тухай бүр Монгол Улсын Ерөнхий аудиторoor батлуулана.

2.3. Чанарын баталгаажуулалтын алба тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу зарим гүйцэтгэгчийн ажилд хяналт тавин дүнг нэгтгэж УЗ-ийн хуралд танилцуулна.

2.4. Төсвийн захирагчийн тухайн жилийн санхүүгийн тайланд гэрээний үндсэн дээр аудит хийх гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /ТБОНӨХБАҮХАТХ/-ийн дагуу сонгон шалгаруулах ажлыг ҮАГ-ын Тамгын газар тухай бүр зохион байгуулна.

2.5. Тус журмын 1.2 дахь заалтыг хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэгчийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

2.5.1. Гүйцэтгэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглабарт хугацаатай нийцсэн эсэх;

- 2.5.2. Гүйцэтгэгч аудитын дүгнэлт, баталгаажуулалтын талаар үүсэх хариуцлагыг Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5⁶ -д заасан хөрөнгийн хариуцлага хүлээх чадамжтай эсэх;
- 2.5.3. Гүйцэтгэгч Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.37-т заасан шаардлагыг хангасан боловсон хүчнээр хангагдан ажиллаж байгаа эсэх;
- 2.5.4. Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа доголдож, ёс зүйн болон мэргэжлийн алдаа зөрчил гаргаж байсан эсэх ;
- 2.5.5. УАГ-аас зохион байгуулсан сургалтад гүйцэтгэгчийн аудиторүүд хамрагдаж сертификат эзэмшсэн эсэх;
- 2.5.6. Гүйцэтгэгч сүүлийн 3 жилийн байдлаар татвар, хураамж, төлбөр гэх мэт улсад төлөх өрийн үлдэгдэлгүй тайлагнагдаж, түүнийг баталгаажуулсан эсэх;
- 2.5.7. Бусад

2.6. Энэхүү журмын 2.5-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан гүйцэтгэгчийг сонгож, сонгогдсон гүйцэтгэгчээр аудит хийлгүүлэх тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ-д мэдээллийг САГ хүргүүлнэ.

2.7.УАГ-аас цаг үеийн шаардлага болон хүний нөөцийн хүрэлцээний байдлаас шалтгаалан санхүүгийн аудитыг гүйцэтгэхэд гэрээт ажилтан ажиллуулж болох бөгөөд УАГ-ын Тамгын газар аудитын ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.

Гурав. Захиалагч, гүйцэтгэгчийн эрх, үүрэг оролцоог тодорхойлох

3.1. Захиалагч, гүйцэтгэгч аудит хийх явцад олж авсан мэдээллийн нууцыг Төрийн аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу хамгаална.

3.2. Аудит хийхэд оролцож байгаа гүйцэтгэгчийн аудиторүүд *“Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”*-ийг мөрдөн ажиллаж, УИХ-ын Байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан *“Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”*-ийг Төрийн аудитын байгууллагад бичгээр гаргаж өгнө.

3.3. Төрийн аудитын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д *“...Аудитын арга хэлбэрийг санхүүгийн удирдлага, шинжлэх ухаан, технологийн дэвшилттэй уялдуулан байнга боловсронгуй болгож үйл ажиллагаанд нэвтрүүлж байна”* гэх эрх зүйн зохицуулалтыг үндэслэн гүйцэтгэгчийн аудиторүүдыг санхүүгийн

⁶ 10.5.Аудитын хуулийн этгээд нь аудитын дүгнэлтийн талаар өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

⁷ 19.3.Аудитын хуулийн этгээд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

19.3.1.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч байх;

19.3.2.захирал, партнер нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй, Институтээс зохих зөвшөөрөл авсан байх;

19.3.3.хоёроос доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх;

19.3.4.аудиторүүд нь мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй байх;

19.3.5.үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник хэрэгслээр хангагдсан байх;

19.3.6.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь гадаадын байгууллага бол тухайн байгууллагын нийт мэргэшсэн нягтлан бодогчдын гуравны хоёроос доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх;

19.3.7.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь гадаадын байгууллага бол тухайн байгууллагын нийт хувьцаа эзэмшлийн гуравны нэгээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, мэргэшсэн нягтлан бодогч эзэмшдэг байх;

19.3.8.аудитын үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байх;

19.3.9.бусад хууль тогтоомжоор заасан нэмэлт шаардлага.

аудитын программ хангамж, арга зүйн сургалтад тухайн жилийн аудит эхлэхийн өмнө хамруулж байна.

3.4 Гүйцэтгэгч санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203, 429 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам" "Санхүүгийн тайлангийн аудитын гарын авлага"-ын дагуу ажиллана.

3.5 Гүйцэтгэгч аудитын ажлын эрсдэлийг өндөр, дунд, бага гэж ангилан үнэлэх бөгөөд түүнд тулгуурлан ҮАГ-ын оролцоог дараах байдлаар жил бүр САГ тогтооно:

3.5.1. Эрсдэл багатай аудитын хувьд, гүйцэтгэгч зөвхөн илрүүлсэн зөрчил дутагдлыг тайлагнах;

3.5.2. Дунд зэргийн эрсдэлтэй аудитын хувьд, гүйцэтгэгч аудитын явцыг мэдээлж, зөрчил, дутагдал илэрсэн эсэхийг тайлагнаж байх;

3.5.3. Эрсдэл өндөртэй аудитын хувьд, гүйцэтгэгчтэй холбоотой ажиллаж, аудитын явцын талаар тогтмол мэдээлэл авч, илрүүлсэн зөрчил дутагдалыг нь хэлэлцэж, арга хандлагын өөрчлөлтийг зөвшилцөж байх, шаардлагатай гэж үзвэл үйлчлүүлэгч байгууллагатай хамтран ажиллана.

Дөрөв. Гэрээ байгуулах

4.1. САГ ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгогдсон гүйцэтгэгч, төсвийн захирагч, төрийн өмчит хуулийн этгээд /цаашид "үйлчлүүлэгч" гэх/-тэй "Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулж, Монгол Улсын Ерөнхий аудиторoor батлуулна.

4.2. Журмын 2.4 болон 2.5-д заасны дагуу Төрийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ сонгон шалгаруулсан гүйцэтгэгчтэй САГ "Аудитын чанарын хяналтын гэрээ" байгуулж, Монгол Улсын Ерөнхий аудиторoor батлуулна.

4.3. Энэхүү журмын 2.6-д заасны дагуу сонгон шалгаруулсан гэрээт ажилтантай Тамгын газар "Гэрээт ажилтан ажиллуулах гэрээ" байгуулан ажиллана.

4.4. Аудитын ажил гүйцэтгүүлэх болон аудитын чанарын хяналтын гэрээний хугацааг талууд харилцан тохиролцох бөгөөд уг хугацаа 3 жилээс илүүгүй байна.

4.5. Аудитын ажлын гэрээ байгуулахад ашиглах "Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ"-ний загварыг энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар, "Аудитын чанарын хяналтын гэрээ"-ний загварыг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар, "Гэрээт ажилтан ажиллуулах тухай гэрээ"-ний загварыг энэхүү журмын 3 дугаар хавсралтаар тус тус тусгасан болно.

4.6. "Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ"-нд захиалагч, гүйцэтгэгч, үйлчлүүлэгч нар оролцон гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

4.6.1. Аудитын ажил хийлгэх гэрээнд **захиалагч** дараах үүрэг хүлээнэ:

а. Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан 2014 оны 203, 429 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам",

“Санхүүгийн тайлангийн аудитын гарын авлага” болон холбогдох бусад арга зүйн материалаар гүйцэтгэгчийг хангах;

- b. Сангийн сайдын 2007 оны 213 дугаар тушаалаар баталсан аудитын ажлын төлбөрийг тогтоох аргачлалын дагуу захиалагчийн гаргасан аудитын ажлын төлбөрийн хэмжээг хянаж, үйлчлүүлэгч, гүйцэтгэгчтэй хэлэлцэж тогтоох;
- c. Захиалагч аудитын ажлын баримт материалыг өөрийн ажлын байранд болон гүйцэтгэгч, үйлчлүүлэгчийн ажлын байранд нягтлах;
- d. Гүйцэтгэгчийн бэлтгэсэн аудитын гэрчилгээ, менежментийн захидал, акт, албан шаардлагыг зохих журмын дагуу хянаж бэлтгэн гаргах;
- e. Гүйцэтгэгчийн аудитын үйлчилгээний төлбөрийн 30 хувийг аудитын ажлын гэрээ байгуулагдсанаар, 60 хувийг аудитын ажил дууссаны дараа гүйцэтгэгчид олгохыг үйлчлүүлэгчид мэдэгдэх;
- f. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6⁸-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд олгохоор үйлчлүүлэгчид мэдэгдэх;
- g. бусад.

4.6.2. Аудитын ажил хийлгэх гэрээнд **үйлчлүүлэгч** дараах үүрэг хүлээнэ:

- a. Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дахь заалтын дагуу аудитын төлбөрийг жилийн төсөвтөө тусгаж батлуулах;
- b. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журмын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабрын дагуу тогтоосон хугацаанд гүйцэтгэгчид ирүүлэх;
- c. Гүйцэтгэгчийн шаардсан аудиттай холбоотой мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;
- d. Гүйцэтгэгчийн аудитын үйлчилгээний төлбөрийн 30 хувийг аудитын ажлын гэрээ байгуулагдсанаар, 60 хувийг аудитын ажил дууссаны дараа захиалагчийн зөвшөөрлийн дагуу олгох;
- e. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд захиалагчийн зөвшөөрлөөр барьцааг буцаан өгөх;
- f. бусад.

4.6.3. Аудитын ажил хийлгэх гэрээнд **гүйцэтгэгч** дараах үүрэг хүлээнэ:

- a. Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль болон Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 203, 429 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, “Санхүүгийн тайлангийн аудитын гарын авлага”, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, энэхүү журам, холбогдох бусад дүрэм, журмын дагуу ажиллах;

⁸ 43.6.Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно.

- b. Гүйцэтгэгч аудитын ажил эхлэхээс өмнө аудитын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, хөтөлбөрийг захиалагчаар хянуулж, батлуулах;
- c. Гүйцэтгэгч батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд захиалагч байгууллагатай уулзалт хийж аудитын явцыг мэдээлж, хэлэлцэж байх;
- d. Гүйцэтгэгчээс үйлчлүүлэгчтэй хийх уулзалтад шаардлагатай тохиолдолд захиалагчийн төлөөллийг оролцуулах;
- e. Захиалагчийн зүгээс аудитын явцыг хянаж шалгахад гүйцэтгэгч аудитын ажлын баримт материалыг бэлэн байлгах;
- f. Гүйцэтгэгч аудитын ажил гүйцэтгэж дууссанаас хойш аудитын ажлын баримт материалыг өөртөө хадгалах бөгөөд Аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5⁹-д заасны дагуу 10 жилийн хугацаанд ажлын болон нотлох баримт материалыг хадгалж, үзэх боломжийг захиалагчид олгох;
- g. Аудитын ажил дуусгавар болгосноор дараах баримтыг захиалагчид хүлээлгэн өгнө:
 - гүйцэтгэсэн ажлын үр дүнг бүртгэсэн баримт материалын жагсаалт;
 - үйлчлүүлэгчийн ирүүлсэн санхүүгийн тайлангийн эх хувь;
 - аудитыг дуусгавар болгох хяналтын хуудас;
 - үйлчлүүлэгчийн удирдлагын гарын үсэг бүхий тайлбар захидал;
 - аудитын хамарсан хүрээ, гол эрсдэлүүд, гаргасан гол дүгнэлт, шийдлүүд, үйлчлүүлэгчийн удирдлагад аудитаар илэрсэн асуудлыг танилцуулсан асуудлын товчоо, дараа жил үргэлжлүүлэн шалгах асуудлын жагсаалт, гэрчилгээ өгөхөөс өмнө тодруулах асуудлын жагсаалт тусгагдсан байх;
 - захиалагчаас акт, албан шаардлага тавих, хуулийн байгууллагад шилжүүлэх, хариуцлага тооцуулах шаардлагатай гэж үзсэн асуудлын жагсаалт, холбогдох үндэслэл, нотлох баримт;

Мөн аудитын төгсгөлд дараах ажлыг гүйцэтгэнэ:

- Үйлчлүүлэгчийн удирдлагад хандсан аудитын тайлан, менежментийн захидал, гэрчилгээний төслийг бэлтгэн захиалагчаар хянуулах;
 - Менежментийн захидал болон гэрчилгээний төслийн талаарх саналыг үйлчлүүлэгчээс авч, хүлээн зөвшөөрөөгүй зөвлөмж байвал судалж, үндэслэлтэй гэж үзвэл зохих засвар өөрчлөлт хийх;
 - Аудитын тайлан, менежментийн захидал болон аудитын гэрчилгээний эцсийн хувилбарыг захиалагчид хүлээлгэн өгөх.
- h. Гүйцэтгэгч аудитын үйлчилгээний төлбөрийн 30 хувийг аудитын ажлын гэрээ байгуулагдсанаар, 60 хувийг аудитын ажил дууссаны дараа захиалагчийн зөвшөөрлийн дагуу нэхэмжлэх;

⁹ 12.5.Аудитын ажлын баримт нь аудитын хуулийн этгээдийн өмч бөгөөд ажлын баримтыг 10 жил хадгална.

- i. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд захиалагчийн зөвшөөрлөөр барьцааг буцаан авах;
- j. бусад.

4.7. “Аудитын чанарын хяналтын гэрээ”-нд захиалагч, гүйцэтгэгч нар оролцон гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

4.7.1. Аудитын чанарын хяналтын гэрээнд **захиалагч** дараах үүрэг хүлээнэ:

- a. Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журамд заасан аудитыг хянан удирдах үйл ажиллагааны арга зүйг үндэслэн аудитын чанарын хяналтыг хэрэгжүүлэх;
- b. Аудитын ажлын шаардлагатай нотлох баримт материалыг өөрийн болон гүйцэтгэгчийн ажлын байранд үзэх;
- c. Аудитын дүгнэлтийг дэмжиж буй эсэхийг нягтлах, эрсдэл ихтэй аудитын хувьд төлөвлөлтийн явцад тодорхойлсон эрсдэлтэй асуудлын талаар гүйцэтгэгчийн хийсэн ажлын чанар, үр дүнг үнэлэх;
- d. Гүйцэтгэгчийн аудитын үе шат бүрт хийсэн ажлын явц, илрүүлэлт, шийдвэрлэх санал, нотлох зүйлс болон ажлын баримттай танилцаж шийдвэрлэх;
- e. Гүйцэтгэгчийн аудитын санал дүгнэлт, тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарт хугацаанд хүлээн авч, аудитын тайлан болон аудитын үе шатны ажилд чанарын хяналт хийж, шаардлагатай үед чанарын баталгаажуулалт хийх;
- f. Үйлчлүүлэгч, иргэн, бусад хуулийн этгээдийн зүгээс ирүүлсэн санал, гомдлыг гүйцэтгэгчтэй хамтран судалж, зохих журмын дагуу шийдвэрлэн, хариу мэдэгдэж байх;
- g. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд олгохоор үйлчлүүлэгчид мэдэгдэх;
- h. бусад.

4.7.2. Аудитын чанарын хяналтын гэрээнд **гүйцэтгэгч** дараах үүрэг хүлээнэ:

- a. Аудитыг хийхдээ Төрийн аудитын тухай хууль болон Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 203, 429 дүгээр тушаалаар баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлага, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, энэхүү журам, холбогдох бусад дүрэм, журмын дагуу ажиллах;
- b. Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.8¹⁰-д заасны дагуу аудитын үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байх;

¹⁰ 19.3.8. аудитын үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байх;

- с. Захиалагчаас чанарын хяналт хийхэд аудитын ажлын болон нотлох баримт материалыг бэлэн байлгах;
- d. Засгийн газрын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг гүйцэтгэх, тайлагнах явцад үйлчлүүлэгчийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, судалгаа, нотлох баримтыг саадгүй гаргаж өгөх;
- e. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд захиалагчийн зөвшөөрлөөр барьцааг буцаан авах;
- f. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8¹¹-д заасан цаглабарт хугацаанд аудитыг дуусгавар болгосноор захиалагчид доорхи аудитын баримт материалыг цаасаар болон цахимаар хүлээлгэж өгнө. Үүнд:
 - хараат бус аудиторын дүгнэлт;
 - хараат бус аудиторын тайлан;
 - санхүүгийн тайлангийн эх хувь болон аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;
 - аудитыг дуусгавар болгосон хяналтын хуудас;
 - үйлчлүүлэгчийн гарын үсэг бүхий тайлбар захидал;
 - ҮАГ-аас хариуцлага тооцуулах шаардлагатай гэж үзсэн асуудлын жагсаалт, холбогдох үндэслэл, нотлох баримт;
 - бусад баримт материал.
- g. Засгийн газрын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үйлчлүүлэгчтэй холбоотой илрүүлсэн зүйлс, хийсэн ажиглалтуудыг нягтлах асуудлыг захиалагч болон үйлчлүүлэгчтэй хэлэлцэх.

Тав. Чанарын хяналт тавих болон баталгаажуулалт

5.1. Гүйцэтгэгчийн гэрээний үндсэн дээр хийж буй аудитад хийх чанарын хяналтыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/94 дүгээр тушаалаар батлагдсан "Аудитын чанарын хяналтын журам"-ын дагуу захиалагч хэрэгжүүлнэ.

5.2. Чанарын баталгаажуулалтын журмын дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан удирдамжийн дагуу хамрах хүрээг тодорхойлон санхүүгийн аудитын түвшинд хийх чанарын баталгаажуулалтын ажлыг хийнэ.

5.3. Захиалагч чанарын хяналтыг хийхдээ аудитын үе шатуудад дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.3.1. Төлөвлөлтийн үе шатанд:

- төсвийн тухай хуульд заасан цаглабрын дагуу аудитын ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг төлөвлөсөн эсэх;
- ажлын хамрах хүрээг зөв тодорхойлсон эсэх;

¹¹ 8.9.8. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон Төрийн өмчийн хороонд хүргүүлэх.

- аудитын урьдчилсан судалгаа хийгдсэн эсэх;
- эрсдэлийг тооцон үнэлж, хэрэгжүүлэх горимыг зөв тодорхойлсон эсэх;
- үйлчлүүлэгчийн холбогдох ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, хангалттай мэдээлэлд үндэслэн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулсан эсэх;
- аудитын багийн гишүүдийн ажлын хуваарь, зохион байгуулалтыг оновчтой зөв тодорхойлсон эсэх;
- холбогдох техник хэрэгслийг урьдчилан бэлтгэх, шаардлагатай шинжээч, мэргэжилтнүүдийг аудитын баг бүрт оролцуулсан эсэхийг тодорхойлох;

5.3.2. Гүйцэтгэлийн үе шатанд:

- аудиторуд аудитыг хийхдээ холбогдох стандартууд, хуулийн заалтуудыг баримталж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу зохих горимыг хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавих;
- Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203 429 дүгээр тушаалаар баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу ажлуудыг гүйцэтгэж, батлагдсан маягыг хөтөлсөн эсэхийг хянах.

5.3.3. Тайлагналын үе шатанд:

- тайлангийн төслийн хэлбэр, бүтцийг хянах;
- тайлангийн төслийн агуулгыг хянах;
- тайлангийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийн хэсэг хангалттай зохистой нотлох баримтаар нотлогдсон эсэхийг хянах, тайлангийн төслийн хавсралтууд бүрэн, зохих ёсоор бэлтгэгдсэн эсэх;
- тайлангийн төсөлд үйлчлүүлэгчээс ирүүлсэн саналыг хэрхэн харгалзан үзсэн, тэр талаарх мэдээллийг тусгасан эсэхийг хянах;
- акт, албан шаардлагын төслийг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөх журам"-ын дагуу хянах.

5.4. Гүйцэтгэгчийн гэрээний үндсэн дээр хийж буй аудитын чанарын хяналтыг аудитын үе шатуудад захиалагчийн менежер гүйцэтгэх бөгөөд энэхүү журмыг баримтлан чанарын хяналтыг хэрэгжүүлнэ.

Зургаа. Гэрээ дүгнэх, хариуцлага ногдуулах

6.1. Захиалагч, гүйцэтгэгчийн гэрээний үндсэн дээр хийж буй аудитын ажил болон аудитын чанарын гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээний биелэлтийн дүнг Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулна.

6.2. Захиалагч гүйцэтгэгчийн гэрээг дүгнэн гэрээний үүргээ биелүүлсэн гэж үзсэн тохиолдолд аудитын үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхийг үйлчлүүлэгчид албан бичгээр мэдэгдэнэ.

6.3. Гүйцэтгэгч, үйлчлүүлэгч холбогдох стандарт, журмыг баримтлаагүй, гэрээний үүрэг, ажлын даалгавар, чанарын шаардлагыг ханган биелүүлээгүй, аудитын багийн гишүүдийг захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчилсөн, багийн гишүүд ёс зүйн зөрчил гаргасан, сонирхлын зөрчил илэрсэн тохиолдолд захиалагч гэрээг цуцлах бөгөөд гарсан хохирлыг буруутай тал хариуцна.

6.4. Аливаа маргааныг хамтран хэлэлцэж, зохих журмаар шийдвэрлэх бөгөөд хэрэв харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.5. Гүйцэтгэгчийн гэрээгээр хийж буй аудитын ажил болон аудитын тайлангийн чанарын гүйцэтгэл хангалтгүй, гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, мөн мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан гүйцэтгэгчийн гэрээг цуцлах дахин сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байх шийдвэрийг Монгол Улсын Ерөнхий аудитор гаргана.

6.6. Энэхүү журмын 6.5-д заасан нөхцөл байдал бий болсон бол буруутай этгээд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

-----0-----

2017 оны 02 дугаар сарын 23-ны
өдрийн 9/ дугаар тушаалаар
батлагдсан журмын нэгдүгээр
хавсралт

УХА0122

БАТЛАВ:

Монгол Улсын Ерөнхий аудитор

АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

.....оны ... дугаар
сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Үндэсний аудитын газар (цаашид "Захиалагч" гэх) Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2, Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.2 дахь заалтыг баримтлан/төсвийн захирагч, төрийн өмчит этгээдийн нэр/ (цаашид "Үйлчлүүлэгч" гэх)-ийноны жилийн эцсийн санхүүгийн тайланд/аудитын байгууллагын нэр/ (цаашид "Гүйцэтгэгч" гэх)-аар аудит хийлгэхээр харилцан тохиролцож, энэхүү Аудитын ажил гүйцэтгүүлэх ГЭРЭЭГ (цаашид "Гэрээ" гэх) байгуулав.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2014 оны 203, 429 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам", "Санхүүгийн тайлангийн аудитын гарын авлага" болон холбогдох бусад арга зүйн материалаар гүйцэтгэгчийг хангах;
- 2.2. Сангийн сайдын 2007 оны 213 дугаар тушаалаар баталсан аудитын ажлын төлбөрийг тогтоох аргачлалын дагуу захиалагчийн гаргасан аудитын ажлын төлбөрийн хэмжээг хянаж, үйлчлүүлэгч, гүйцэтгэгчтэй хэлэлцэж тогтоох;
- 2.3. Захиалагч аудитын ажлын баримт материалыг өөрийн ажлын байранд болон гүйцэтгэгч, үйлчлүүлэгчийн ажлын байранд нягтлах;
- 2.4. Гүйцэтгэгчийн бэлтгэсэн аудитын гэрчилгээ, менежментийн захидал, акт, албан шаардлагыг зохих журмын дагуу хянаж бэлтгэн гаргах;
- 2.5. Гүйцэтгэгчийн аудитын үйлчилгээний төлбөрийн 30 хувийг аудитын ажлын гэрээ байгуулагдсанаар, 60 хувийг аудитын ажил дууссаны дараа гүйцэтгэгчид олгохыг үйлчлүүлэгчид мэдэгдэх;
- 2.6. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд олгохоор үйлчлүүлэгчид мэдэгдэх;

- 2.7. Үйлчлүүлэгч, иргэн, бусад хуулийн этгээдийн зүгээс ирүүлсэн санал, гомдлыг гүйцэтгэгчтэй хамтран судалж, зохих журмын дагуу шийдвэрлэн, хариу мэдэгдэж байх;
- 2.8. бусад.

Гурав. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

- 3.1. Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дахь заалтын дагуу аудитын төлбөрийг жилийн төсөвтөө тусгаж батлуулах;
- 3.2. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журмын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабрын дагуу тогтоосон хугацаанд гүйцэтгэгчид ирүүлэх;
- 3.3. Гүйцэтгэгчийн шаардсан аудиттай холбоотой мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;
- 3.4. Гүйцэтгэгчийн аудитын үйлчилгээний төлбөрийн 30 хувийг аудитын ажлын гэрээ байгуулагдсанаар, 60 хувийг аудитын ажил дууссаны дараа захиалагчийн зөвшөөрлийн дагуу олгох;
- 3.5. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа болон тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд захиалагчийн зөвшөөрлөөр барьцааг буцаан олгох
- 3.6. бусад.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 4.1. Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203, 429 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам", "Санхүүгийн тайлангийн аудитын гарын авлага", Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, энэхүү журам, холбогдох бусад дүрэм, журмын дагуу ажиллах;
- 4.2. Гүйцэтгэгч аудитын ажил эхлэхээс өмнө аудитын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, хөтөлбөрийг захиалагчаар хянуулж, батлуулах;
- 4.3. Гүйцэтгэгч батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд захиалагч байгууллагатай уулзалт хийж аудитын явцыг мэдээлж, хэлэлцэж байх;
- 4.4. Гүйцэтгэгчээс үйлчлүүлэгчтэй хийх уулзалтад шаардлагатай тохиолдолд захиалагчийн төлөөллийг оролцуулах;
- 4.5. Захиалагчийн зүгээс аудитын явцыг хянаж шалгахад гүйцэтгэгч аудитын ажлын баримт материалыг бэлэн байлгах;
- 4.6. Гүйцэтгэгч аудитын ажил гүйцэтгэж дууссанаас хойш аудитын ажлын баримт материалыг өөртөө хадгалах бөгөөд 10 жилийн хугацаанд ажлын болон нотлох баримт материалыг авч үзэх боломжийг захиалагчид олгох;
- 4.7. Гүйцэтгэгч аудитын үйлчилгээний төлбөрийн 30 хувийг аудитын ажлын гэрээ байгуулагдсанаар, 60 хувийг аудитын ажил дууссаны дараа захиалагчийн зөвшөөрлийн дагуу нэхэмжлэх;
- 4.8. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа болон тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд захиалагчийн зөвшөөрлөөр барьцааг буцаан авах;
- 4.9. Аудитын ажил дуусгавар болсоны дараа дараах зүйлийг захиалагчид хүлээлгэн өгнө:
 - гүйцэтгэсэн ажлын үр дүнг бүртгэсэн баримт материалын жагсаалт;
 - үйлчлүүлэгчийн ирүүлсэн санхүүгийн тайлангийн эх хувь;

- аудитыг дуусгавар болгох хяналтын хуудас;
- үйлчлүүлэгчийн удирдлагын гарын үсэг бүхий тайлбар захидал;
- аудитын хамарсан хүрээ, гол эрсдэлүүд, гаргасан гол дүгнэлт, шийдлүүд, үйлчлүүлэгчийн удирдлагад аудитаар илэрсэн асуудлыг танилцуулсан асуудлын товчоо, дараа жил үргэлжлүүлэн шалгах асуудлын жагсаалт, гэрчилгээ өгөхөөс өмнө тодруулах асуудлын жагсаалт тусгагдсан байх;
- захиалагчаас акт, албан шаардлага тавих, хуулийн байгууллагад шилжүүлэх, хариуцлага тооцуулах шаардлагатай гэж үзсэн асуудлын жагсаалт, холбогдох үндэслэл, нотлох баримт;

Мөн аудитын төгсгөлд дараах ажлыг гүйцэтгэнэ:

- Үйлчлүүлэгчийн удирдлагад хандсан аудитын тайлан, менежментийн захидал, гэрчилгээний төслийг бэлтгэн захиалагчаар хянуулах;
- Менежментийн захидал болон гэрчилгээний төслийн талаарх саналыг үйлчлүүлэгчээс авч, хүлээн зөвшөөрөөгүй зөвлөмж байвал судалж, үндэслэлтэй гэж үзвэл зохих засвар өөрчлөлт хийх;
- Аудитын тайлан, менежментийн захидал болон аудитын гэрчилгээний эцсийн хувилбарыг захиалагчид хүлээлгэн өгөх.

4.10. Бусад

Тав. Хариуцлага

5.1. Гүйцэтгэгч, үйлчлүүлэгч талууд холбогдох стандарт, журмыг баримтлаагүй, гэрээний үүрэг, ажлын даалгавар, чанарын шаардлагыг ханган биелүүлээгүй, аудитын багийн гишүүдийг захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчилсөн, багийн гишүүд ёс зүйн зөрчил гаргасан, сонирхлын зөрчил илэрсэн тохиолдолд захиалагч гэрээг цуцлах бөгөөд үүссэн зардал, учирсан хохирлыг буруутай тал хариуцна.

5.2. Аливаа маргааныг хамтран хэлэлцэж, эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

5.3. Гүйцэтгэгчийн гэрээгээр хийж буй аудитын ажил болон аудитын тайлангийн чанарын гүйцэтгэл хангалтгүй, гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, мөн мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан гүйцэтгэгчийн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах, дахин сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байх шийдвэрийг Монгол Улсын Ерөнхий аудитор гаргана.

5.4. Энэхүү журмын 6.5-д заасан нөхцөл байдал бий болсон бол буруутай этгээд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.5. Гүйцэтгэгч нь Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасны дагуу аудитын дүгнэлтийн талаар өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

Зургаа. Гэрээний хугацаа

6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталснаас хойш ... жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал
Овог, нэр

Гарын үсэг

Хаяг.....

Холбоо барих утас.....

Имэйл.....

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал
Овог, нэр

Гарын үсэг

Хаяг.....

Холбоо барих утас.....

Имэйл.....

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал
Овог, нэр


Гарын үсэг

Хаяг.....

Холбоо барих утас.....

Имэйл.....

2017 оны 02 дугаар сарын 23-ны
өдрийн 14 дугаар тушаалаар
батлагдсан журмын хоёрдугаар
хавсралт



БАТЛАВ:
Монгол Улсын Ерөнхий аудитор

АУДИТЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ГЭРЭЭ

....оны ... дугаар
сарын ... өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.2 дахь заалтыг баримтлан нэг талаас Үндэсний аудитын газар, нөгөө талаас/ аудитын байгууллагын нэр/ (цаашид "гүйцэтгэгч "гэх) нар 201. оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитад чанарын хяналт хийлгэхээр харилцан тохиролцож, энэхүү Аудитын чанарын хяналтын ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журамд заасан аудитыг хянан удирдах үйл ажиллагааны арга зүйг үндэслэн аудитын чанарын хяналтыг хэрэгжүүлэх;
- 2.2. Аудитын ажлын шаардлагатай нотлох баримт материалыг өөрийн болон гүйцэтгэгчийн ажлын байранд үзэх;
- 2.3. Аудитын дүгнэлтийг дэмжиж буй эсэхийг нягтлах, эрсдэл ихтэй аудитын хувьд төлөвлөлтийн явцад тодорхойлсон эрсдэлтэй асуудлын талаар гүйцэтгэгчийн хийсэн ажлын чанар, үр дүнг үнэлэх;
- 2.4. Гүйцэтгэгчийн аудитын үе шат бүрт хийсэн ажлын явц, илрүүлэлт, шийдвэрлэх санал, нотлох зүйлс болон ажлын баримттай танилцаж шийдвэрлэх;
- 2.5. Гүйцэтгэгчийн аудитын санал дүгнэлт, тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарт хугацаанд хүлээн авч, аудитын тайлан болон аудитын үе шатны ажилд чанарын хяналт хийж, шаардлагатай үед чанарын баталгаажуулалт хийх;
- 2.6. Үйлчлүүлэгч, иргэн, бусад хуулийн этгээдийн зүгээс ирүүлсэн санал, гомдлыг гүйцэтгэгчтэй хамтран судалж, зохих журмын дагуу шийдвэрлэн, хариу мэдэгдэж байх;
- 2.7. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж

- дууссаны дараа тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд олгохоор үйлчлүүлэгчид мэдэгдэх;
- 2.8. Үйлчлүүлэгч, иргэн, бусад хуулийн этгээдийн зүгээс ирүүлсэн санал, гомдлыг гүйцэтгэгчтэй хамтран судалж, зохих журмын дагуу шийдвэрлэн, хариу мэдэгдэж байх;
- 2.9. бусад.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 3.1. Аудитыг хийхдээ Төрийн аудитын тухай хууль болон Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203, 429 дүгээр тушаалаар баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлага, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, энэхүү журам, холбогдох бусад дүрэм, журмын дагуу ажиллах;
- 3.2. Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.8¹²-д заасны дагуу аудитын үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байх;
- 3.3. Захиалагчаас чанарын хяналт хийхэд аудитын ажлын болон нотлох баримт материалыг бэлэн байлгах;
- 3.4. Засгийн газрын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг гүйцэтгэх, тайлагнах явцад үйлчлүүлэгчийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, судалгаа, нотлох баримтыг саадгүй гаргаж өгөх;
- 3.5. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д заасны дагуу 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа болон тухайн аудитын чиглэлээр эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд захиалагчийн зөвшөөрлөөр барьцааг буцаан авах;
- 3.6. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8¹³-д заасан цаглабарт хугацаанд аудитыг дуусгавар болгосноор захиалагчид доорхи аудитын баримт материалыг цаасаар болон цахимаар хүлээлгэж өгнө. Үүнд:
- хараат бус аудиторын дүгнэлт;
 - хараат бус аудиторын тайлан;
 - санхүүгийн тайлангийн эх хувь болон аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;
 - аудитыг дуусгавар болгосон хяналтын хуудас;
 - үйлчлүүлэгчийн гарын үсэг бүхий тайлбар захидал;
 - ҮАГ-аас хариуцлага тооцуулах шаардлагатай гэж үзсэн асуудлын жагсаалт, холбогдох үндэслэл, нотлох баримт;
 - бусад баримт материал.
- 3.7. Засгийн газрын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үйлчлүүлэгчтэй холбоотой илрүүлсэн зүйлс, хийсэн ажиглалтуудыг нягтлах асуудлыг захиалагч болон үйлчлүүлэгчтэй хэлэлцэх.

¹² 19.3.8.аудитын үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байх;

¹³ 8.9.8.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон Төрийн өмчийн хороонд хүргүүлэх.

Дөрөв. Хариуцлага

- 4.1. Гүйцэтгэгч, үйлчлүүлэгч талууд холбогдох стандарт, журмыг баримтлаагүй, гэрээний үүрэг, ажлын даалгавар, чанарын шаардлагыг ханган биелүүлээгүй, аудитын багийн гишүүдийг захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчилсөн, багийн гишүүд ёс зүйн зөрчил гаргасан, сонирхлын зөрчил илэрсэн тохиолдолд захиалагч гэрээг цуцлах бөгөөд үүссэн зардал, учирсан хохирлыг буруутай тал хариуцна.
- 4.2. Аливаа маргааныг хамтран хэлэлцэж, эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.
- 4.3. Гүйцэтгэгчийн гэрээгээр хийж буй аудитын ажил болон аудитын тайлангийн чанарын гүйцэтгэл хангалтгүй, гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, мөн мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан гүйцэтгэгчийн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах, дахин сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байх шийдвэрийг Монгол Улсын Ерөнхий аудитор гаргана.
- 4.4. Энэхүү журмын 6.5-д заасан нөхцөл байдал бий болсон бол буруутай этгээд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 4.5. Гүйцэтгэгч нь Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасны дагуу аудитын дүгнэлтийн талаар өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

Тав. Гэрээний хугацаа

5.1. Энэхүү гэрээ нь ... жилийн хугацаатай байх бөгөөд талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал
Овог, нэр

Гарын үсэг

Хаяг.....

Холбоо барих утас.....

Имэйл.....

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал
Овог, нэр

Гарын үсэг

Хаяг.....

Холбоо барих утас.....

Имэйл.....

2017 оны 02 дугаар сарын 23-ны
өдрийн дугаар тушаалаар
батлагдсан журмын гуравдугаар
хавсралт

УХА0122

БАТЛАВ:

Монгол Улсын Ерөнхий аудитор

ГЭРЭЭТ АЖИЛТАН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

.... оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар:.....

Улаанбаатар
хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү Гэрээт ажилтан ажиллуулах тухай гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г нэг талаас Үндэсний аудитын газар /цаашид "захиалагч" гэх/-ыг төлөөлж, нөгөө талаас/цаашид "гэрээт ажилтан" гэх/ нар /хамтад нь "Талууд" гэх/ МУ-ын Иргэний хуулийн 359 дугаар зүйлийн 359.1, Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д заасныг үндэслэн дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 2.1. Ажил үүрэг гүйцэтгэх газар /байршил/: УБ хот, Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын IV байр, 3 давхарт байрлах Үндэсний аудитын газар
- 2.2. Гүйцэтгэх ажил үүрэг: Ажил үүрэг гүйцэтгэж эхлэх өдөр:
- 2.3. Гэрээний үргэлжлэх хугацаа: ний өдөр хүртэл байна.
- 2.4. Ажлын төлбөрийн хэмжээ:төгрөг, (Энэхүү үнийн дүнгээс Хувь хүний орлогын албан татварыг суутган тооцно)
- 2.5. Ажлын хөлсийг ажлын гүйцэтгэлийг дүгнэснээр сар бүр олгоно.

ГУРАВ. ГЭРЭЭТ АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Захиалагчаас Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
- 3.2. Энэхүү гэрээтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг байгууллагын удирдлагад гаргаж шийдвэрлүүлэх;
- 3.3. Ажлын үр дүн гүйцэтгэлийг бодитой үнэлж дүгнүүлэх, энэхүү гэрээнд заасан хөлс авах;
- 3.4. Өөрийн мэргэжил, ур чадварыг дайчлан, гэрээнд заасан ажлыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх;

3.5. Монгол Улсын хууль тогтоомж, тухайн ажил үүргийг гүйцэтгэхтэй холбоотой тус байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, байгууллагын удирдлагаас өгсөн заавар, удирдамжын дагуу энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

3.6. Гэрээт ажлын гүйцэтгэлийн талаар захиалагчийн удирдлагад тухай бүр мэдээлж, зааварчилгаа авах;

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

4.1. Гэрээт ажилтнаас Монгол Улсын хууль тогтоомж, Захиалагчийн дотоод журам, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

4.2. Гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлгээ дүгнэлт өгөх;

4.3. Гэрээт ажилтныг ажлын даалгаварт заасан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хууль тогтоомж, журам, зааварчилгаа, мэдээллээр хангах;

4.4. Гэрээт ажилтан нь гэрээнд заасан үүргээ зөрчсөн, хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд энэ талаар 1 удаа сануулах ба заасан хугацаанд үр дүн гараагүй тохиолдолд энэхүү гэрээг дангаар цуцлах;

4.5. Гэрээт ажилтны албан ёсоор тавьсан санал, хүсэлтийг хүлээн авч шуурхай арга хэмжээ авч, шийдвэрлэх;

4.6. Гэрээнд заасан ажлыг зохих ёсоор гүйцэтгэсэн тохиолдолд төлбөрийг төлөх үүрэгтэй.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь нөгөө талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

5.2. Захиалагчийн албан бичиг, үйл ажиллагаатай холбогдох мэдээлэл, аудитын тайлан нь нууцын зэрэглэлтэй бол аудитын тайлан дахь мэдээллийн нууцыг гэрээний хугацаанд болон гэрээ дуусгавар болсны дараа чанд хадгалж, нууцыг ямар нэгэн байдлаар алдахаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авах бөгөөд хувийн сонирхолд ашиглах, бусдад дамжуулах, тараах, хэвлэн нийтлэхийг хатуу хориглоно.

5.3. Энэхүү гэрээнд заасан нууц хадгалах үүргээ санаатайгаар буюу санамсаргүйгээр биелүүлээгүйгээс материаллаг болон материаллаг бус хохирол учруулбал Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу тухайн зөрчлийн үр дагаврыг бүрэн хариуцах бөгөөд учруулсан хохирлыг бүрэн барагдуулна.

5.4. Гэрээт ажилтан нь ажил хүлээлцэх явцад ажлын баримт болон архивын баримт материал дутаасан, үрэгдүүлсэн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

- 5.5. Гэрээт ажилтан нь захиалагчийн архивын хадгаламжийн нэгжээс баримт материал олшруулж хувьдаа ашиглах бусад байдлаар байгууллагын мэдээллийг гадагш задруулахыг хориглоно.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1. Захиалагчийн үйл ажиллагааны хүрээнд мөрдөгдөж буй дүрэм, журам, заавар нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 6.2. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.3. Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэн гэрээнд хавсаргана. Ийнхүү оруулсан нэмэлт өөрчлөлт нь хууль зүйн хувьд гэрээт ажилтан ажиллуулах гэрээтэй адил хүчинтэй байна.
- 6.4. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд адил хүчинтэй байна.
- 6.5. Талуудын хооронд гарсан маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал
Овог, нэр

Гарын үсэг

Хаяг.....

Холбоо барих утас.....

Имэйл.....

ГЭРЭЭТ АЖИЛТАН:

Овог, нэр

Гарын үсэг

Хаяг.....

Холбоо барих утас.....

Имэйл.....